



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/712

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,  
тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 46 дугаар зүйлийн 46.1.3, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газарт олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл нийлүүлэгчийг сонгох тендерийн 1-р багц 6-23 сартай хүүхдийг олон найрлагатай бичил тэжээлээр хангах тендерийг 13261380 /арван гурван сая хоёр зуун жаран нэгэн мянга гурван зуун наяд/ төгрөгөөр Азифарм ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (Б.Валя)-д зөвшөөрсүгэй.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 2 дугаар багц Жирэмсэн болон хөхүүл ээжүүдийг олон найрлагатай бичил тэжээлээр хангах тендерийг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцыг онцгой тендер шалгаруулалтын журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101357